



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

ХАЛААСНЫ ХУЛГАЙН ДИНАМИКИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ
ХЭЛТСИЙН ЗАХИАЛГААР "ЦОГЦ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ГҮЙЦЭТГЭВ

2024

Энэхүү судалгааг “Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газар”-ын харьяа “Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс”-ийн санаачилгаар “Цогц Хөгжлийн Үндэсний Төв”-ийн судалгааны баг гүйцэтгэв. Судалгааны багийг мэдээллээр бүрэн хангаж, судалгааны бүхий л шатанд дэмжлэг үзүүлж ажилласан “Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс”-ийн хамт олон, бүрэлдэхүүнд гүн талархал илэрхийлье.

СУДАЛГААНЫ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

БАГИЙН АХЛАГЧ

М.Энхбадрал Социологич

СУДЛААЧ ГИШҮҮД

Л.Галбаатар Эрх зүйч

Г.Доржтүвдэн Социологич

Ж.Батболд Социологич

Б.Ган-Өсөх Эрх зүйч

ГАРЧИГ

Графикийн жагсаалт	3
УДИРТГАЛ	4
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	5
ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОХ ХЭМ ХЭМЖЭЭ, ШҮҮХИЙН ПРАКТИК	6
1.1. Халаасны хулгайн гэмт хэрэгт холбогдох эрх зүйн орчин	6
1.2. Халаасны хулгайн гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик	7
1.3. Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага	8
1.4. Шүүхийн шийдвэрийн жишээний хүснэгт	15
ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТ ӨРТСӨН ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	20
2.1. Хүн ам зүйн мэдээлэл	20
2.2. Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн нөхцөл байдал	21
2.3. Хохирогчдын цагдаагийн байгууллагад хандсан туршлага, сэтгэл ханамж	25
2.4. Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчдын хохирлыг барагдуулсан нөхцөл байдал	30
ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТЭД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ	31
3.1 Халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлтэд тулгарч буй хүндрэлүүд	31
3.2 Албан хаагчид болон ажиллах орчин нөхцөл	31
3.3 Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн албан хаагчдын ажлын орчин	32
3.4 Халаасны хулгайн гэмт хэргийн хор хөнөөл	32
3.5 Халаасны хулгайн гэмт хэрэгт холбогдох эрх зүйн орчин	32
ДҮГНЭЛТ	34
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	36

Графикийн жагсаалт

График 1. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал.....	20
График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин	20
График 3. Судалгаанд оролцогчдын төрж, өссөн газар.....	20
График 4. Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн давтамж.....	21
График 5. Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн давтамж, хүйсээр	21
График 6. Халаасны хулгайд алдсан эд зүйлсийн эзлэх хувиар	21
График 7. Халаасны хулгайд өртсөн байршил, хувиар	22
График 8. Халаасны хулгайд өртсөн нөхцөл байдал.....	22
График 9. Цагдаад хандахаас өөр бусад арга хэмжээ авсан эсэх, насны бүлгээр.....	23
График 10. Цагдаад хандахаас өөр бусад аргаар хайсан хэлбэр.....	23
График 11. Халаасны хулгайд өртсөн цаг	24
График 12. Халаасны хулгайд өртсөн үеийн цаг агаарын төлөв байдал	24
График 13. Халаасны хулгайд өртөх үедээ өмсөж байсан хувцас	24
График 14. Халаасны хулгайд эд зүйлээ алдсан байршил нь камерын хяналттай эсэх	24
График 15. Эд зүйлээ алдсаны дараагаар хаана, хэрхэн хандах талаар мэдэж байсан эсэх ..	25
График 16. Цагдаагийн байгууллагад өргөдөл гаргахад зарцуулсан хугацаа	25
График 17. Цагдаагийн байгууллага өргөдөл гомдолд эргэн хариу өгсөн хугацаа	26
График 18. Цагдаагийн байгууллага таны гаргасан гомдол, мэдээллийн дагуу хэрэг нээсэн эсэх	26
График 19. Гар утсаа хулгайд алдсан бол цагдаа танд хувийн мэдээллээ алдахаас сэргийлэх талаар зөвлөмж өгсөн.....	26
График 20. Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ (0-10 оноогоор).....	27
График 21. Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, хохирлоо нөхөн төлүүлсэн байдлаар (0-10 оноогоор)	27
График 22. Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, хувийн мэдээллээ хамгаалах зөвлөмж өгсөн эсэхээр	28
График 23. Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, өргөдлийн хариу авсан хугацаагаар (0-10 оноогоор).....	28
График 24. Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн сэтгэл ханамжийн түвшин.....	29
График 25. Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн сэтгэл ханамж, насны бүлгээр.....	29
График 26. Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн сэтгэл ханамж, өргөдлийн хариу авсан хугацаагаар.....	30
График 27. Хохирлоо төлүүлж чадсан байдал	30
График 28. Хохирлоо бүрэн төлүүлж чадсан бол хэрхэн төлүүлсэн хэлбэр.....	30
График 29. Хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй шалтгаан	30

УДИРТГАЛ

Халаасны хулгай нь хувь хүмүүсийн халаас, цүнхнээс үнэт зүйлийг нууцаар хулгайлах гэмт хэргийн нэг хэлбэр бөгөөд дэлхий даяар нийгэмд сөрөг нөлөө үзүүлдэг өргөн тархсан, хор хөнөөлтэй гэмт хэрэг юм. Гэмт хэргийн тархалт нь өөр өөр бүс нутаг, нөхцөл байдалд харилцан адилгүй байж болох ч олон нийтийн аюулгүй байдал, хувь хүний сайн сайхан байдал, эдийн засгийн тогтвортой байдалд үзүүлэх сөрөг нөлөөг дутуу үнэлж болохгүй.

Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэгчид нь зохион байгуулалттай ихэнхдээ мэргэшсэн байдаг бөгөөд олон улсын хэмжээнд халаасны хулгай нь хууль сахиулах ажиллагааны томоохон асуудал болсоор байна.¹

Энэхүү судалгаа нь Монгол дахь халаасны хулгайн гэмт хэргийн хэв маяг, нөлөөлж буй хүчин зүйлс, шийдвэрлэх боломжуудыг судлах зорилготой.

Нийслэл хотын хэмжээнд 2023 онд халаасны хулгайн 3993 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс 94.8 хувийг татгалзаж шийдвэрлэсэн байна. Эдгээр гомдол мэдээллийг “гэмт хэргийн шинжгүй”, “гар утас нь хулгайд алдагдсан эсэх нь тодорхойгүй буюу иргэн хаяж үрэгдүүлсэн”, “бусад хэргийн” гэх шалтгаанаар татгалзаж шийдвэрлэжээ. Цагдаа гомдлын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулахгүйгээр татгалзаж шийдвэрлэх нь иргэд хохирч үлдэх, цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл сулрах нөхцөлүүдийг үүсгэж байна. Нөгөө талаас гэмт этгээдүүдэд ял завших боломж үүсэж байна.

Бусад улс орнуудад хийгдсэн судалгаагаар халаасны хулгайн гэмт хэргийн зохион байгуулалтын төрлүүд, халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг гаргаж, хэрэгжүүлж иржээ. Мөн хуулийн хүрээнд халаасны хулгайд оногдуулах ялын бодлого харилцан адилгүй байна. Тухайлбал АНУ-д халаасны хулгайн гэмт хэрэгтэнд багадаа 1-5 жил, хохирлын хэмжээнээс хамааран 10 хүртэлх жилээр хорих ял оногдуулж байна.² Эдгээр улс орнуудын халаасны хулгайд оногдуулж буй ялын бодлого болон Монгол Улсын эрүүгийн хуулийн холбогдох хэсэгт заасан энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого болон энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практикт шинжилгээ хийж санал зөвлөмж боловсруулах шаардлагатай юм.

Монгол дахь халаасны хулгайн гэмт хэргийн динамикийг ойлгох нь зайлшгүй чухал бөгөөд хэд хэдэн шалтгаантай. Нэгдүгээрт, энэ нь иргэдийн аюулгүй байдалд шууд нөлөөлж, амьдрах орчны амар тайван байдал, итгэлийг алдагдуулж, нийгэм, эдийн засгийн хөгжилд саад учруулж байна. Хоёрдугаарт, халаасны хулгайн гэмт хэрэг нь хотын ядуурал, тэгш бус байдал, хуулийн хэрэгжилтийн үр дүн муутай зэрэг өргөн хүрээтэй асуудлуудтай огтлолцож, нотолгоонд суурилсан цогц шийдэл хэрэгтэйг харуулж байна.

¹ [Pickpocketing: A Survey of the Crime and Its Control \(upenn.edu\)](https://www.upenn.edu/pickpocketing/)

² [What Is Pickpocketing? | Law Offices of Kenneth A. Stover \(kenstoverlaw.com\)](https://www.kenstoverlaw.com/what-is-pickpocketing/)

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны хамрах хүрээ

Судалгааны хүрээнд 2023 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчдоос утсаар судалгаа авч, халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх албаны албан хаагчид болон хохирогчидтой чанарын ганцаарчилсан ярилцлага хийсэн.

№	Түүвэр	Судалгааны аргачлал
1	ЦЕГ-т бүртгэлтэй халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчид	Утсаар холбогдож судалгаа /computer assisted telephone interview/
2	Халаасны хулгайн гэмт хэргийг хариуцаж буй цагдаагийн албан хаагч	Ганцаарчилсан ярилцлага /КП-key informant interview/
3	Халаасны хулгайн гэмт хэрэгт холбогдох эрх зүйн орчин болон шүүхийн практикт шинжилгээ хийнэ.	Баримт бичгийн шинжилгээ /Documentary analise/
4	Халаасны хулгайн гэмт хэргийн статистик мэдээлэлд шинжилгээ хийх	Баримт бичгийн шинжилгээ /Documentary analise/

Судалгааны түүврийн хэмжээ

№	Судалгааны хамрах хүрээ	Түүврийн хэмжээ		
		Тоон судалгаа	Ганцаарчилсан ярилцлага	Нийт
1	ЦЕГ-т бүртгэлтэй халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчид	500	0	500
2	Халаасны хулгайн гэмт хэргийг хариуцаж буй цагдаагийн албан хаагч	-	7	7
3	Нийт	500	7	507

Судлах зүйл

Судалгааны судлах зүйлийг дараах 3 ангилалд хувааж 7 асуудлын хүрээнд судаллаа.

№	Ангилал	Судлах зүйл
1	Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогч	Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн нөхцөл байдал
		Хохирогчдын цагдаагийн байгууллагад хандсан туршлага
		Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчдын хохирол барагдуулсан нөхцөл байдал
2	Цагдаагийн байгууллага	Халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлтэд тулгарч буй хүндрэл, бэрхшээл
3	Халаасны хулгайн гэмт хэрэгт холбогдох эрх зүйн зохицуулалтууд	Халаасны хулгайн гэмт хэрэгт холбогдох эрх зүйн орчин
		Халаасны хулгайн гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик

ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОХ ХЭМ ХЭМЖЭЭ, ШҮҮХИЙН ПРАКТИК

1.1. Халаасны хулгайн гэмт хэрэгт холбогдох эрх зүйн орчин

Монгол Улсад хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тусгайлсан хөтөлбөр батлан хэрэгжүүлж байв. Тодруулбал, Засгийн газрын 1997 оны 122 дугаар тогтоолоор 1997-2001 онд хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр, төлөвлөгөө батлан ажилласан ба Засгийн газрын 2002 оны 137 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар 2002-2005 онд хэрэгжүүлэх “Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөр” баталж байжээ. Энэ үед хулгайн гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн 50 орчим хувийг эзэлж байв.

Улсын дээд шүүхийн 2003 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Монгол Улсын Эрүүгийн хуулийн 34, 35, 36, 37 дугаар зүйлийн заалтыг тайлбарлах тухай” 10 дугаар тогтоолд “...гүйцэтгэгч...” гэдэгт тухайн гэмт хэргийг санаатайгаар өөрөө гардан үйлдсэн этгээдийн явдал бөгөөд гэмт үйлдлийн арга, зэвсэг хэрэгслийг сонгосон байна. Жишээлбэл: Хэд хэдэн этгээд халаасны хулгай хийх зорилгоор автобусанд сууж, хамжигч нар нь хүмүүсийг шахаж түлхэн анхаарлыг нь сарниулж өгөхөд, хохирогчийн халааснаас мөнгө, эд зүйл авсан этгээд нь гүйцэтгэгч болно. Гэмт хэргийг гардан гүйцэтгэгч нь нэг буюу хэд хэдэн этгээд байж болох бөгөөд хоёр буюу түүнээс дээш тооны этгээд гэмт хэргийг гардан үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэгч гэж үзнэ. Хэрэг хариуцах чадваргүй хүн, бага насны хүүхэд, адгуус амьтан зэргийг ашиглаж өөрийн гэмт санаа зорилгоо биелүүлсэн этгээдийг гүйцэтгэгчид тооцно гэж халаасны хулгайгаар жишээгээр тайлбар хийж байжээ.

Өнөөдөр Монгол Улсад халаасны хулгайн гэмт хэргийн талаар тусгайлан заагаагүй бөгөөд энэ төрлийн хэрэг нь хулгайлах гэмт хэрэгт хамаарна. Ингэхдээ 300,000 мянган төгрөгөөс доош үнийн дүнтэй эд зүйл хулгайлсан нь гэмт хэрэгт тооцогдохгүй, хулгайлах зөрчил болно. Тодруулбал,

- Зөрчлийн тухай хуулийн 8.6 дугаар зүйлийн 1-т “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтад хамруулж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна” гэж,
- Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1-т “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж,
- Мөн зүйлийн тайлбарт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж,
- Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.3-т “бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг буюу 300,000 мянган төгрөгийг ойлгоно гэж тус тус заасан.

Гэхдээ халаасны хулгайг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол эд зүйлийн үнийн дүнгээс үл хамааран хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хүндрүүлнэ. Тодруулбал,

- Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3-т зааснаар энэ гэмт хэргийг: байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйлийн 1-т “Гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг зохион

байгуулалттай гэмт бүлэг гэнэ” гэж заасан тул халаасны хулгайн гэмт хэрэгт энэ бүлэг нэгэн адил хамаарна.

Үүнээс гадна халааны хулгайн эд зүйл нь 5 сая төгрөгөөс дээш байх тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлнэ. Тодруулбал,

- Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2-т зааснаар энэ гэмт хэргийг: 2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж; 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж; 2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Мөн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.1-т “их хэмжээний хохирол” гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг ойлгоно гэж заасан.

Мөн бүх төрлийн гэмт хэрэг үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалттай бөгөөд халаасны хулгайн хэрэг үйлдсэн хүүхдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн 2-т зааснаар 14-16 насны хүн энэ хуулийн тусгай ангийн 17.1/Хулгайлах/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

1.2. Халаасны хулгайн гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практик

Шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn цахим хуудаснаас халаасны хулгайн асуудлаарх шүүхийн шийдвэрүүдийг түүвэрлэн авч үзэв. Энэ хүрээнд 2022-2024 онд шүүхээс гаргасан шийдвэрийн түүврийг хавсралтад тусгав. Эндээс үзэхэд халаасны хулгайн гэмт хэргийг дараах байдлаар шүүхээс шийдвэрлэж байна. Үүнд:

- Ихэвчлэн Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар халаасны хулгайн гэмт хэргийг шийдвэрлэжээ. Халаасны хулгайн эд зүйл, жишээ нь гар утаснуудыг буцаан олгосон тул бусдад төлөх төлбөргүйд тооцох, үүнийг эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд хамааруулж байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т “...учруулсан хохирлыг төлсөн” гэх нөхцөлд хамааруулж байна.
- Харин ихэнх тохиолдолд “хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдсонгүй” гэж шүүхийн шийдвэрт дурдаж байна. Гэхдээ халаасны хулгайн гэмт хэргийг удаа дараа үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тогтоохдоо Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад “энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн” гэх эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал” гэснийг баримталж, шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, оногдуулсан хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлсэн жишиг байна.

Үүнээс гадна “урьд нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт шүүхээр удаа дараа ял шийтгэгдэж байсан атлаа засрал хүмүүжлийг олоогүй дахин өмчлөх эрхийг эсрэг буюу хулгайлах гэмт хэрэг үйлдсэн зэргийг харгалзан гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэх эрүүгийн хариуцлагын зорилгын хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ял шийтгэл оногдуулах нь зүйтэй” гэж дүгнэсэн ч нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих” гэсэн гурван төрлийн ялаас зорчих эрхийг хязгаарлах ялыг сонгосон шүүхийн шийдвэр гарсан нь ял шийтгэлийн талаар нэгдсэн жишиг тогтоогүй болохыг харуулж байна.

1.3. Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын туршлага

Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын тусгайлсан хэм хэмжээ байхгүй. Энэ төрлийн гэмт хэргийг тухайн улс бүр дотоодын хууль тогтоомжийн дагуу зохицуулж байна. Энэ хэсэгт зарим улсын халаасны хулгайг хуульчилсан жишээг харьцуулан авч үзье.

	АНУ	Их Британи	Франц	Герман	Япон
Ангилал	Хулгайлсан эд зүйлсийн үнэ цэнээс хамааран жижиг хулгай эсвэл их хэмжээний хулгай гэж ангилж байна	Хулгайн гэмт хэрэгт хамаарах ба ердийн хулгай, өмчлөх замаар хулгайлах, олсон зүйлийг завших гэж ангилж байна	Ердийн хулгайн гэмт хэрэгт хамаарна	Халаасны хулгай	Хулгайн гэмт хэрэгт хамаарна
Ял шийтгэл	Торгууль, хорих, тэнсэн харгалзах, нөхөн төлбөр	Торгох, Хорих, Нийтэд тустай ажил хийлгэх	Торгох, Хорих, Нийтэд тустай ажил хийлгэх	Торгох, Хорих	Торгох, Хорих
Хүндрүүлэх нөхцөл	Давтан үйлдэх, эмзэг бүлгийн хүмүүсийн эсрэг үйлдэх, хүч хэрэглэх	Хүнээс хулгайлах, Орон байрнаас хулгайлах	Хүнээс хулгайлах, Тээврийн хэрэгсэл хулгайлах	Хүнээс хулгайлах, Тээврийн хэрэгсэл хулгайлах	Хүнээс хулгайлах, Тээврийн хэрэгсэл хулгайлах
Хөнгөрүүлэх нөхцөл	Анх удаа үйлдэх, Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хохирол барагдуулах	Анх удаа үйлдэх, Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хохирол барагдуулах	Анх удаа үйлдэх, Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хохирол барагдуулах	Анх удаа үйлдэх, Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хохирол барагдуулах	Анх удаа үйлдэх, Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, хохирол барагдуулах

АНУ-н Невада муж улсын хуулийн дагуу халаасны хулгай нь хүнд гэмт хэрэг бөгөөд тухайн хүнд оногдуулах шийтгэл нь авсан зүйлийн үнэ цэнээс хамаарна. Хэрэв хөрөнгийн үнэ 3500 доллароос бага байсан бол уг гэмт хэргийг С зэрэглэлийн гэмт хэрэг гэж үзнэ. Тухайн хүн 1-5 жилийн хорих ял, 10,000 долларын торгууль төлөх боломжтой, 3500 доллар ба түүнээс дээш үнэлгээтэй эд хөрөнгийг авах нь В ангиллын гэмт хэрэг болдог. Энэ гэмт хэрэгт 1-10 жилийн хорих ял, 10,000 доллар хүртэл торгууль ногдуулдаг.³

³ N.R.S. 205.270 <https://law.justia.com/codes/nevada/2010/title15/chapter205/nrs205-270.html>

Их Британид Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тухай 1968 оны хуулийн дагуу хулгайн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг 7 хүртэлх жилээр хорих зохицуулалттай. Харин тээврийн хэрэгсэл зэрэг хулгайн эд зүйлийн төрлөөс хамаарч ял шийтгэлийн хэмжээ ялгаатай байдаг.⁴

Францын Эрүүгийн хуулийн 311-3 дугаар зүйлд зааснаар хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг 3 жил хорих, 45000 еврогоор торгох шийтгэл оногдуулна. Харин 311-4 дүгээр зүйлд зааснаар хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайн гэмт хэрэгт 5 жил хорих, 75000 еврогоор торгох шийтгэлтэй.⁵

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 246 дугаар зүйлд зааснаар хулгайлах гэмт хэрэгт 3 хүртэл жил хорих, торгох шийтгэлтэй ба завдах үйлдэлд мөн шийтгэл оногдуулна. Мөн 248а дугаар зүйлд зааснаар бага үнийн дүнтэй эд зүйл хулгайлсныг зөвхөн 246 дугаар зүйлд заасан гэмт хэргийг шалгах хүрээнд яллана.⁶

Японы Эрүүгийн хуулийн 235 дугаар зүйлд зааснаар бусдын эд хөрөнгийг хулгайлсан этгээдийг 10 жил хүртэлх хугацаагаар хорих, эсвэл 500,000 хүртэлх иенээр торгох ял шийтгэнэ.⁷ Эдгээр улсын хувьд ял шийтгэлийн хэмжээний хувьд харилцан адилгүй хэдий ч бусад нөхцөл нь төстэй байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулиар халаасны хулгайн гэмт хэрэгт оногдуулж байгаа ял шийтгэлийн төрөл, хэлбэр

Халаасны хулгайн гэмт хэрэг буюу халаас, түрийвч, цүнхнээс хулгай хийх нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хулгайн гэмт хэргийн ангилалд багтдаг. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан хулгайлах гэмт хэргийн зохицуулалт нь зөвхөн халаасны хулгайгаар хязгаарлахгүйгээр хулгайн гэмт хэргийн өргөн хүрээг хамарсан. Мөн Зөрчлийн тухай хуулийн 8.6 дугаар зүйлд заасан хулгайлах зөрчилд шийтгэл оноохоор тусгасан зэрэг нь хулгайн эд зүйлийн үнэлгээнээс хамаарч ялын төрөл, хэлбэрийг тодорхойлох онцлогтой юм.

Халаасны хулгайн гэмт хэргийн талаарх эрх зүйн орчин, шийтгэл нь улс орнуудад харилцан адилгүй байдаг ч ерөнхий хандлага нь ихэвчлэн ижил байдаг. Тодруулбал, олон улс орон халаасны хулгайн гэмт хэргийг хулгайн гэмт хэрэгт хамааруулан ангилж, гэмт хэргийн ноцтой байдлаас хамаарч шийтгэл ногдуулдаг.⁸

Барууны олон оронд халаасны хулгайг ихэвчлэн хүнд гэмт хэрэг гэж үзэж торгууль ногдуулах, нийгэмд тустай ажил хийх, богино хугацаагаар хорих ялаар шийтгэдэг. Гэсэн хэдий ч өмчийн эсрэг гэмт хэргийн гаралт өндөртэй буюу халаасны хулгайн гэмт хэргийг зохион байгуулалттай үйлдэх гэмт хэрэгт тооцдог орнуудад шийтгэл нь илүү хатуу байна.⁹

Монгол Улсын халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын үр нөлөөг үнэлэхийн тулд дараах хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзан үзэх нь чухал юм.

⁴ Theft Act 1968 <https://www.legislation.gov.uk/ukpga/1968/60>

⁵ Code pénal

https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070719/LEGISCTA000006165324/?anchor=LEGIARTI000006418127#LEGIARTI000006418127

⁶ German Criminal Code (Strafgesetzbuch – StGB) https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html

⁷ Penal Code (Act No. 45 of 1907 https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/3581/en#je_pt2ch38at1

⁸ <https://mcaleerlaw.net/levels-of-larceny-from-petty-theft-to-grand-larceny/#:-:text=Due%20to%20the%20higher%20value,and%20a%20permanent%20criminal%20record.>

⁹ <https://www.findlaw.com/criminal/criminal-charges/larceny-penalties-and-sentencing.html>

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх: Гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн үйлдлийг таслан зогсоохын тулд ял шийтгэл хатуу байх.¹⁰
- Тохирсон байх: Ял шийтгэл нь үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон байх ёстой.
- Үр ашигтай байх: Эрх зүйн тогтолцоо нь халаасны хулгайн гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, шийдвэрлэхэд үр ашигтай байх ёстой.
- Олон нийтийн ойлголт: Халаасны хулгайн гэмт хэргийн эсрэг шүүхийн тогтолцоо ямар хариу арга хэмжээ авдаг талаарх олон нийтийн ойлголт нь олон нийтийн аюулгүй байдал, хохирогчийн сэтгэл ханамжид нөлөөлдөг.

Монгол Улсад хулгай, тэр дундаа халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчин олон улсын жишигт нийцэж байгаа ч хэрэгжилтийн үр дүн, оногдуулах шийтгэлийн хэмжээ харилцан адилгүй байна. Ял шийтгэлийн бодлого нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үр нөлөөтэй байх нөхцөлийг сайжруулахын тулд Монгол Улс дараах зүйлийг анхаарч үзэх нь зүйтэй.¹¹

- Хууль сахиулах ажиллагааг бэхжүүлэх: Халаасны хулгайчдыг илрүүлэх, баривчлах чадварыг сайжруулахын тулд хууль сахиулах байгууллагуудын сургалт, нөөцөд хөрөнгө оруулалт хийх.
- Олон нийтэд сурталчлах ажил: Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга техник, энэ төрлийн гэмт хэргийн үр дагаврын талаар олон нийтэд сурталчлах.
- Олон улсын хамтын ажиллагаа: Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх мэдээлэл, сайн туршлагыг бусад улс оронтой хуваалцах.
- Эрүүгийн хуулийн зохицуулалтыг үнэлж, шинэчлэх: Халаасны хулгайн гэмт хэрэгт оногдуулах шийтгэл тохиромжтой, үр дүнтэй байх нөхцөлийг хангах үүднээс Эрүүгийн хуулийн зохицуулалтыг тогтмол үнэлж байх.

Эдгээр алхмыг хийснээр Монгол Улс халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаагаа улам бэхжүүлж, иргэдээ энэ гэмт хэргээс хамгаалах боломжтой.

Бусад улс орны шүүхийн практикт “удаа дараа” энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулдаг ял шийтгэл

Халаасны хулгайн гэмт хэрэг дадал болгосон, мэргэжлийн гэмт хэрэг болсон тохиолдолд олон улс оронд илүү хатуу шийтгэл оногдуулдаг. Үүнтэй холбоотой дараах нийтлэг арга зам байна.¹²

- Ял шийтгэлийг нэмэгдүүлэх:
 - Хорих хугацааг нэмэгдүүлсэн: Давтан гэмт хэрэг үйлдсэн хүмүүс анх удаа гэмт хэрэг үйлдэж байгаатай харьцуулахад илүү урт хугацаагаар хорих ял авч болно.

¹⁰ <https://www.istor.org/stable/42705413>

¹¹ https://scholarship.law.upenn.edu/cgi/viewcontent.cgi?referer=&httpsredir=1&article=7467&context=penn_law_review

¹² <https://boatwrightlegal.com/grand-larceny-punishment/#:~:text=Repeat%20Offenders,prison%20terms%20and%20higher%20fines.https://www.sentencingcouncil.org.uk/wp-content/uploads/Effectiveness-of-Sentencing-Options-Review-FINAL.pdf>

- Заавал биелүүлэх ялын доод хэмжээ: Зарим улсад тодорхой хэмжээний шийтгэл ногдуулахын тулд давтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд заавал хорих ялын доод хэмжээг тогтоодог.
- Дадал болгосон гэмт этгээдтэй холбоотой хууль тогтоомж:
 - Шийтгэлийг нэмэгдүүлэх: Эдгээр хууль нь тодорхой хугацаанд хулгайн гэмт хэрэг үйлдэж олон удаа ял шийтгүүлсэн хүмүүст оногдуулах ялыг нэмэгдүүлэх боломжтой байхаар зохицуулсан.
 - “Гурван тохиолдлын” хууль: Зарим улс орнууд хулгайн гэмт хэргийг гурав дахь удаа давтан үйлдсэн этгээдэд урт хугацаагаар хорих ял оногдуулдаг хуулийг хэрэгжүүлсэн.
- Хянан харгалзах, тэнсэх хязгаарлалт
 - Илүү хатуу хяналт: Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд цахим хяналт тавих, хөл хорио тогтоох зэрэг хатуу хянан харгалзах, тэнсэх нөхцөлтэй байж болно.
 - Хянан харгалзах, тэнсэх хугацааг хүчингүй болгох: Хянан харгалзах, тэнсэх нөхцөлийг зөрчсөн тохиолдолд шууд хорих ял оногдуулах үндэслэл болно.
- Нөхөн төлбөр, торгууль:
 - Санхүүгийн өндөр торгууль: Давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд өндөр торгууль ногдуулах эсвэл хохирогчдод нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээлгэж болно.
- Нийтэд тустай ажил хийлгэх:
 - Заавал нийтэд тустай ажил хийлгэх: Ял шийтгэлийн нөхцөл болгож давтан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тодорхой хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэхийг шаардаж болно.

Шийтгэлийн тодорхой удирдамж, практик нь улс орон бүрд, тэр байтугай тухайн улс дотор ихээхэн ялгаатай байж болохыг анхаарах нь чухал юм. Хулгайлсан эд хөрөнгийн үнэ цэнэ, гэмт хэрэгтний үйлдсэн хэргийн түүх, орон нутаг дахь ял шийтгэлийн удирдамж зэрэг хүчин зүйлүүд нь халаасны хулгайн гэмт хэргийг давтан үйлдсэн тохиолдолд оногдуулах шийтгэлийн хүнд байдалд нөлөөлж байна.¹³

Гэмт этгээдийг ял шийтгэл эдэлж дууссаны дараа хэрхэн хяналт тавьдаг, ажлын байраар хангах, мэргэжлийн чиг баримжаа олгох, дадлагад хамруулж нийгэмшүүлэх

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих ангиас суллах, нийгэмшүүлэх:¹⁴

¹³ https://english.elpais.com/elpais/2014/04/10/inenglish/1397141607_871230.html
https://sc.scourt.go.kr/sc/engsc/pdf/Chapter_10_Crimes_of_Larceny.pdf

¹⁴ https://scholar.google.com/scholar?q=Post-prison+rehabilitation+programs+for+pickpockets&hl=en&as_sdt=0&as_vis=1&oi=scholar

Мониторинг, хяналт. Гэмт этгээдүүд суллагдсаны дараа гэмт хэргийн хүнд байдал болон тусгайлсан хууль тогтоомжийн зохицуулалтаас хамааран тэдэнд янз бүрийн хэлбэрийн хяналт, мониторинг хийж болдог бөгөөд дараах нийтлэг арга бий.¹⁵

- Хянан харгалзах: Энэ нь хар тамхины шинжилгээ хийлгэх, хөл хорио тогтоох, олон нийтийн ажил хийх гэх мэт нөхцөлийг хариуцсан хяналтын байцаагчид тогтмол хянуулах явдал юм.
- Тэнсэх: Хянан харгалзахтай адил боловч ихэвчлэн шоронгоос эрт суллагдсан хүмүүст хамаарна. Тэнсэх үйл ажиллагаанд хяналт тавих алба хаагчид гэмт хэрэгтнүүдийг хянаж, зөрчил гаргавал болзол тавьж, хугацаанаас нь тэнсэнт цуцалж болно.
- Цахим хяналт: Энэ нь гэмт хэрэгтний байршил, үйл ажиллагааг хянахын тулд шагайн бугуйвч зэрэг төхөөрөмжийг ашиглах явдал юм.
- Засан хүмүүжүүлэх хөтөлбөрүүд: Эдгээр хөтөлбөр нь гэмт хэрэгтнүүдийг нийгэмд дахин нэгтгэхэд нь туслах зорилгоор зөвлөгөө өгөх, ажлын байранд сургах, орон сууцны тусалцаа үзүүлэх зэрэг олон төрлийн үйлчилгээг санал болгодог.

Хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн удирдамж, нийгэмшүүлэх. Амжилттай нийгэмших боломжийг нэмэгдүүлэхийн тулд ихэнх улсад гэмт хэрэгтнүүдэд ажил олох, ажлын ур чадварыг хөгжүүлэх, нийгмийн харилцаа холбоог сэргээхэд нь туслах хөтөлбөрүүдийг санал болгодог дараах нийтлэг арга зам бий:

- Мэргэжлийн сургалт: Хорих анги, олон нийтийн байгууллагууд гэмт хэрэгтнүүдэд мужаан, гагнуур, компьютерын программчлал зэрэг хөдөлмөрийн зах зээлд хэрэгтэй чадвар эзэмшүүлэхийн тулд мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг санал болгодог.
- Ажлын байранд зуучлах үйлчилгээ: Эдгээр үйлчилгээ нь гэмт хэрэгтнүүдийг ажил олгогчтой холбож, анкет бичих, ярилцлагад бэлдэх ур чадвар олгох замаар ажил олоход нь тусалдаг.
- Менторын хөтөлбөрүүд: Менторууд гэмт хэрэг үйлдэгчдийг нийгэмд эргэн хөл тавихад нь заавар, дэмжлэг үзүүлнэ. Тэд ажил хайх, орон байр болон бусад бэрхшээлийг шийдвэрлэхэд тусална.
- Дадлага хийх: Эдгээр боломж нь гэмт хэрэгтнүүдэд тодорхой чиглэлээр туршлага хуримтлуулах боломжийг олгодог бөгөөд ингэснээр тэдний ажил эрхлэх байдлыг нэмэгдүүлэх боломжтой.
- Нийгмийн ур чадварын сургалт: Харилцаа холбоо, зөрчилдөөнийг шийдвэрлэх зэрэг нийгмийн ур чадварыг заадаг хөтөлбөрүүд нь гэмт хэрэгтнүүдэд эерэг харилцааг бий болгож, ирээдүйд гэмт хэргийн зан үйлээс зайлсхийхэд тусалдаг.

¹⁵ <https://study.com/learn/lesson/prison-rehabilitation-programs.html#:~:text=The%20most%20successful%20types%20of,ready%20to%20re%2Denter%20society.https://www.ppic.org/publication/california-prison-programs-and-reentry-pathways/#:~:text=Rehabilitation%20programs%20include%20substance%20abuse,management%2C%20and%20family%20relationships%20programs.>

- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ: Зөвлөгөө, эмчилгээ нь гэмт хэрэгтнүүдийн гэмт хэргийн зан үйлд нөлөөлж болзошгүй сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг.

Засгийн газар болон олон нийт дээр дурсан дэмжлэг үзүүлснээр давтан гэмт хэргийн гаралтыг бууруулж, өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан хүмүүсийг нийгмийн үр бүтээлтэй гишүүн болоход нь тусалж чадна.

Гэмт хэргийн замаар алдагдсан гар утсыг олж тогтоох чиглэлээр улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ.

- Гар утас хулгайлахтай тэмцэх, гар утсыг олох олон улсын хандлага¹⁶

Хэд хэдэн улс орон гар утасны хулгайтай тэмцэх стратеги хэрэгжүүлсэн бөгөөд үүнд үүрэн холбооны операторуудтай хамтран ажиллах, хууль эрх зүйн орчин, технологийн шийдлүүдийг тусгасан байдаг.¹⁷

Их Британи:

- Эрх зүйн орчин: Их Британид гар утасны хулгай зэрэг хулгайн гэмт хэргийн эсрэг хатуу хууль байдаг.
- Операторын хамтын ажиллагаа: Их Британийн үүрэн холбооны операторууд хулгайлагдсан утсыг хянахын тулд IMEI дугаар ашиглан хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажилладаг.
- Технологийн шийдэл:
 - IMEI блокдох: Мобайл сүлжээ нь хулгайлагдсан утсыг сүлжээнд нь нэвтрэхийг хориглох боломжтой.
 - Зайнаас хянах, устгах: Зарим ухаалаг гар утасны үйлдвэрлэгчид хэрэглэгчдэд алдагдсан эсвэл хулгайлагдсан төхөөрөмжийн өгөгдлийг алсаас хянах, устгах боломжийг санал болгодог.

АНУ:

- Эрх зүйн орчин: Холбооны болон муж улсын хуулиудад гар утасны хулгайг хулгайн гэмт хэргийн хүрээнд шийдвэрлэдэг.
- Операторын хамтын ажиллагаа: АНУ-ын үүрэн холбооны операторууд гар утасны хулгайтай тэмцэхийн тулд хууль сахиулах байгууллага болон салбарын бүлгүүдтэй хамтран ажилладаг.
- Технологийн шийдэл:
 - Операторын хар жагсаалт: Хулгайлагдсан утсыг оператор компаниуд хар жагсаалтад оруулж, сүлжээнд ашиглахаас сэргийлнэ.

¹⁶ https://eucpn.org/sites/default/files/document/files/2009_Toolbox%2011_ENG_LR_0.pdf

¹⁷ https://www.researchgate.net/publication/342349455_A_SOFTWARE_TOOL_FOR_RECOVERING_LOST_MOBILE_PHONES_USING_REAL-TIME_TRACKING

- Зайнаас төхөөрөмжийг удирдах: Хөдөлгөөнт төхөөрөмжийн удирдлагын (MDM) шийдлүүд нь хулгайлагдсан төхөөрөмжүүдийн байршлыг тогтоох, түгжих, устгахад тусална.

Австрали:

- Эрх зүйн орчин: Австралийн хуулиудад гар утасны хулгайг хулгайн гэмт хэргийн хүрээнд шийдвэрлэдэг.
- Операторын хамтын ажиллагаа: Австралийн үүрэн холбооны операторууд хулгайлагдсан утсыг хянахын тулд хууль сахиулах байгууллагатай хамтран ажилладаг.
- Технологийн шийдэл:
 - IMEI блокдох: Хулгайлагдсан утсыг оператор компаниуд хар жагсаалтад оруулж болно.
 - Зайнаас төхөөрөмжийг удирдах: Хөдөлгөөнт төхөөрөмжийн удирдлагын (MDM) шийдлүүд нь хулгайлагдсан төхөөрөмжүүдийг алсаас удирдах боломжтой.

Сингапур:

- Эрх зүйн орчин: Сингапурт гар утасны хулгай зэрэг хулгайн эсрэг хатуу хууль үйлчилдэг.
- Операторын хамтын ажиллагаа: Сингапурын үүрэн холбооны операторууд гар утасны хулгайтай тэмцэхийн тулд хууль сахиулах байгууллагатай нягт хамтран ажилладаг.
- Технологийн шийдэл:
 - IMEI блокдох: Хулгайлагдсан утсыг сүлжээнээс хаах боломжтой.
 - Зайнаас төхөөрөмжийг удирдах: Хөдөлгөөнт төхөөрөмжийн удирдлагын (MDM) шийдлүүд нь хулгайлагдсан төхөөрөмжүүдийг алсаас удирдах боломжтой.

Монгол Улсын хувьд эдгээр стратегийг хэрэгжүүлснээр гар утасны хулгайтай үр дүнтэй тэмцэж, иргэдээ хамгаалах боломжтой.

1.4. Шүүхийн шийдвэрийн жишээний хүснэгт

Шүүхийн шийдвэр	Шүүхийн дүгнэлт	Хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл	Ял шийтгэл
<p>Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2024 оны 07 сарын 17 өдөр Дугаар 2024/ШЦТ/597</p>	<p>Насанд хүрээгүй хохирогч болон бусад хохирогч нарын хувцасны халааснаас гар утсыг хулгайлан авсан үйл баримт нь мөрдөн байцаалтын явцад цуглуулж бэхжүүлсэн, хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар хөдөлбөргүй нотлогдсон бөгөөд хохирогч нар нь өөрсдийн эзэмшлийн гар утсыг халаасандаа хийж, өөрийн өмч хөрөнгийг хадгалах, хамгаалах чадвар нь түр суларсан нөхцөл байдлыг далимдуулж, шүүгдэгч Ц.***** нь бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан үйлдэл нь хулгайлах гэмт хэргийн шинжийг бүрэн хангасан гэж үзнэ.</p>	<p>Гар утаснуудыг буцаан олгосон тул бусдад төлөх төлбөргүүд тооцов. 3 хохирогчийн 3 ширхэг гар утсыг биет байдлаар буцаан өгсөн нь хөнгөрүүлэх нөхцөл байдалд хамаарна.</p>	<p>Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, нөгөө талаас түүний хувийн байдалд хамаарах урьд нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт шүүхээр удаа дараа ял шийтгэгдэж байсан атлаа засрал хүмүүжлийг олоогүй дахин өмчлөх эрхийг эсрэг буюу хулгайлах гэмт хэрэг үйлдсэн зэргийг харгалзан гэмт хэрэг үйлдсэн хүнийг цээрлүүлэх эрүүгийн хариуцлагын зорилгын хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ял шийтгэл оногдуулах нь зүйтэй. Иймд дээр дурдсан нөхцөл байдлуудыг харгалзан үзэж шүүгдэгч Ц.*****-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “нийтэд тусгай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих” гэсэн гурван төрлийн ялаас зорчих эрхийг хязгаарлах ялыг сонгож, уг зүйл хэсэгт зааснаар түүнд 0 /хоёр/ жилийн хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэв.</p>
<p>Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2024 оны 05 сарын 21 өдөр Дугаар 2024/ШЦТ/374</p>	<p>Гэмт хэрэг үйлдэхдээ шунахай сэдэлтэй, амар хялбар аргаар мөнгө олох зорилготой, гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлджээ. Өөрөөр хэлбэл өөрсдийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн байна. Шүүгдэгч нар шүүх хуралдаанд гэм буруугийн талаар маргаагүй болно. Шүүгдэгч ***, *** нарын бүлэглэж үйлдсэн хэргийн улмаас 3,514,500 төгрөгийн, шүүгдэгч ***, ***, ***-ын бүлэглэж болон дангаараа үйлдлийн улмаас бусдад 11,564,500 төгрөгийн хохирол тус тус учирсан буюу хулгайлах гэмт хэргийн улмаас бусдад бага хэмжээнээс дээш хохирол учруулсан байх</p>	<p>Хулгайлах гэмт хэргийг шүүгдэгч ***, хэргийг шүүгдэгч ***, ***, *** нар нь бүлэглэж болон шүүгдэгч *** нь дангаараа үйлдэхдээ адил аргаар буюу олон нийтийн үйлчилгээний газраар үйлчлүүлж байсан хохирогч нарын анхаарал сарнисан байдлыг нь ашиглан халааснаас нь гар утсыг хулгайлсан нөхцөл байдал байх ба тэдний үйлдэлд</p>	<p>Шүүгдэгч ***, ***, ***-ыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3, 3.1 дүгээр зүйлийн 1, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1 (нэг) жилийн хугацаагаар хорих ял, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1 (нэг) жилийн хугацаагаар хорих ял; Шүүгдэгч ***, ***, *** нарыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1, 3.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 6 (зургаа) сарын хугацаагаар хорих ял тус тус шийтгэсэн.</p>

<p>Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2024 оны 03 сарын 06 өдөр Дугаар 2024/ШЦТ/238</p>	<p>тул тэдний үйлдлийг хулгайлах гэмт хэрэгт тооцох үндэслэлтэй байна.</p>	<p>Шүүгдэгч С.Ө нь насанд хүрээгүй Ш.Мөнх-Үйлсийн өмчлөлийн Ай Фоне Экс загварын гар утас 1 ширхэг, иргэн Д.Бямбаагийн Ай Фоне про макс 14 загварын гар утас 1 ширхгийг, 2 удаагийн үргэлжилсэн үйлдлээр хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан үйлдэл нь “Хулгайлах” гэмт хэргийн үндсэн шинжийг хангасан байна.</p>	<p>хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй.</p>	<p>Шүүгдэгч С.Ө-д 1 жил 6 сарын хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэсэн. Шүүгдэгч С.Ө-д Улаанбаатар хотын нутаг дэвсгэрээс гадагш явахыг тус тус хориглох, өөр дүүрэг, орон нутагт зорчих, оршин суух газраа өөрчлөхдөө эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах үүрэг хүлээлгэн зорчих эрхийг хязгаарлаж, түүнд хяналт тавихыг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт даалгасан.</p>
<p>Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2024 оны 02 сарын 29 өдөр Дугаар 2024/ШЦТ/165</p>	<p>Шүүгдэгч 3.Чинзориг нь 2023 оны 6 дугаар сарын 01-ээс 02-нд шилжих шөнө Төв аймгийн Заамар сумаас Улаанбаатар хотын чиглэлд зорчихоор Л.Алтанцэцэгийн өмчлөлийн тээврийн хэрэгсэлд суугаад Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр 5 шарын автобусны буудал орчим буухдаа хохирогчийн гар цүнхнээс 840.000 төгрөгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч бага хэмжээнээс дээш буюу 840.000 төгрөгийн хохирол учруулсан</p>	<p>3.Чинзоригт эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд хүндрүүлэх нөхцөл тогтоогдоогүй, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол нөхөн төлсөн нь хөнгөрүүлэх нөхцөл байдалд хамаарна.</p>	<p>Хорих ял оногдуулахгүйгээр 1 /нэг/ жилийн хугацаагаар тэнссэн. 3.Чинзоригт тэнссэн хугацаанд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.5-д заасан “оршин суух газар, ажлаа өөрчлөх зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх” үүрэг хүлээлгэсэн.</p>	<p>Хорих ял оногдуулахгүйгээр 1 /нэг/ жилийн хугацаагаар тэнссэн. 3.Чинзоригт тэнссэн хугацаанд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.5-д заасан “оршин суух газар, ажлаа өөрчлөх зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх” үүрэг хүлээлгэсэн.</p>
<p>Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2023 оны 12 сарын 05 өдөр Дугаар 2023/ШЦТ/1442</p>	<p>Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал (шүүгдэгч нар шунахайн сэдэлтээр, согтуурсан үедээ, амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор хохирогч нарын халааснаас болон ажлаа гүйцэтгэж явааг нь далимдуулан текэн дээр тавьсан байсан гар утаснуудыг нууцаар, хууль бусаар авч хохирогч нарын өмчлөх эрхэд халдсан), учирсан хохирол, хор уршгийн шинж чанар (хохилогч нарт нийт 3,200,000 төгрөгийн</p>	<p>Шүүх шүүгдэгч *****д эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5, 6.6 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл</p>	<p>Оногдуулсан 6 сарын хорих ял дээр урьд Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 2022/ШЦТ/1337 дугаар шийтгэх тогтоолоор оногдуулсан 1 жил 2 сарын хорих ялыг нэмж нэгтгэн нийт биечлэн эдлэх хорих ялын хэмжээг 1 (нэг) жил 8 (найм) сараар тогтоосон. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч *****д оногдуулсан хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн.</p>	<p>Оногдуулсан 6 сарын хорих ял дээр урьд Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 2022/ШЦТ/1337 дугаар шийтгэх тогтоолоор оногдуулсан 1 жил 2 сарын хорих ялыг нэмж нэгтгэн нийт биечлэн эдлэх хорих ялын хэмжээг 1 (нэг) жил 8 (найм) сараар тогтоосон. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч *****д оногдуулсан хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн.</p>

<p>Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2023 оны 11 сарын 08 өдөр Дугаар 2023/ШЦТ/870</p>	<p>эд хөрөнгийн хохирол учирсан, насанд хүрээгүй хохирогч *****гар утсыг биет байдлаар буцааж өгсөн, хохирогч *****700,000 төгрөг төлсөн, хохирогч *****ын хохирол төлөгдөөгүй, тэрээр “Гомдолтой, хуулийн дагуу шийдүүлмээр байна” гэх), шүүгдэгч *****хувийн байдал (гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, тогтоол биелүүлэхийг хойшуулсан хугацаанд санаатай гэмт хэрэг дахин үйлдсэн, хохирол төлөгдөөгүй, хохирол төлөх талаар санал санаачилга гаргаагүй, арга хэмжээ аваагүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогогүй), шүүгдэгч *****гийн хувийн байдал (гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулсан, эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогогүй)-ыг тус тус харгалзсан.</p>	<p>байдал тогтоогдоогүйг, шүүгдэгч *****д эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан “учруулсан хохирлыг төлсөн”-ийг эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүйг тус тус дурдаж байна.</p>	<p>Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч С.*****-Ойдовыг 360 (гурван зуун жар) цаг нийгэд тустай ажил хийлгэх ял шийтгэсэн.</p>
<p>Шүүгдэгч С.*****-Ойдовт эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.***** дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан “тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэн” эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдсон бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий</p>	<p>Шүүгдэгч С.*****-Ойдовт эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.***** дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан “тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэн” эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдсон бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий</p>	<p>байдал тогтоогдоогүйг, шүүгдэгч *****д эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан “учруулсан хохирлыг төлсөн”-ийг эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүйг тус тус дурдаж байна.</p>	<p>Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч С.*****-Ойдовыг 360 (гурван зуун жар) цаг нийгэд тустай ажил хийлгэх ял шийтгэсэн.</p>
<p>Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2023 оны 11 сарын 08 өдөр Дугаар 2023/ШЦТ/870</p>	<p>эд хөрөнгийн хохирол учирсан, насанд хүрээгүй хохирогч *****гар утсыг биет байдлаар буцааж өгсөн, хохирогч *****700,000 төгрөг төлсөн, хохирогч *****ын хохирол төлөгдөөгүй, тэрээр “Гомдолтой, хуулийн дагуу шийдүүлмээр байна” гэх), шүүгдэгч *****хувийн байдал (гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, тогтоол биелүүлэхийг хойшуулсан хугацаанд санаатай гэмт хэрэг дахин үйлдсэн, хохирол төлөгдөөгүй, хохирол төлөх талаар санал санаачилга гаргаагүй, арга хэмжээ аваагүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогогүй), шүүгдэгч *****гийн хувийн байдал (гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулсан, эрхэлсэн тодорхой ажилгүй, орлогогүй)-ыг тус тус харгалзсан.</p>	<p>байдал тогтоогдоогүйг, шүүгдэгч *****д эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан “учруулсан хохирлыг төлсөн”-ийг эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүйг тус тус дурдаж байна.</p>	<p>Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч С.*****-Ойдовыг 360 (гурван зуун жар) цаг нийгэд тустай ажил хийлгэх ял шийтгэсэн.</p>

	<p>ангийн 6.6 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй болно.</p>		
<p>Баянзүрх дүүргийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2022 оны 11 сарын 02 өдөр Дугаар 2022/ШЦТ/1611</p>	<p>Шүүгдэгч Ц.Б. Ц-д эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлсөн нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасан хөнгөрүүлэх нөхцөл байдал болох бөгөөд хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдоогүй болно.</p>	<p>Шүүгдэгч Б.Ц нь хохирогч Г.А-гийн Ай фони 11 загварын гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар хууль бусаар авч 1.100.000 төгрөгийн, мөн өдөр хохирогч Х.Г-гийн Рэдми К-30 загварын гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч 450.000 төгрөгийн, хохирогч Б.М-гийн Рэдми нөг 8 про загварын гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч 330.000 төгрөгийн, мөн өдөр хохирогч Г.Г-гийн Рэдми нөг 9с загварын гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч 390.000 төгрөгийн хохирлыг тус тус учруулж бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч хулгайлах гэмт хэргийг үйлдсэн болох нь шүүгдэгч Ц.Б.Ц, хохирогч Г.А, Х.Г, Б.М, Г.Г нарын мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн мэдүүлэг, “Дамно” ХХК, “К” ХХК-ий эд хөрөнгийн үнэлгээний тайлан, мөрдөгчийн тэмдэглэл болон хуульд заасан үндэслэл журмын дагуу хавтаст хэрэгт бэхжүүлэгдэн, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэгдсэн нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байна.</p>	<p>Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Цацралмаад 1 /нэг/ жил 6 /зургаан/ сар хорих ялаар шийтгэсэн. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3,4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Ц-д оногдуулсан 1 /нэг/ жил 6 /зургаан/ сарын хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлсэн.</p>
<p>Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол</p>	<p>Шүүгдэгч Н.Ө-ын Шүүгдэгч Н.Ө-ын хувьд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад заасан</p>	<p>Шүүгдэгч Н.Ө нь 2022 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Баянгол дүүргийн 13 дугаар хороо, “И-март” худалдааны төвийн урд талын автобусны буудлын орчимд насанд хүрээгүй хохирогч Д.Д-ын халааснаас “Айфоне Икс эс макс” загварын гар утсыг</p>	<p>Шүүгдэгч Н.Ө-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.6 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Н.Ө-г оногдуулсан хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлсэн.</p>

<p>2022 оны 10 сарын 12 өдөр Дугаар 2022/ШЦТ/754</p>	<p>хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч 990,000 төгрөгийн хохирол учруулсан болох нь насанд хүрээгүй хохирогчийн мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн мэдүүлэг, хөрөнгийн үнэлгээний тайлан, камерын бичлэгт үзлэг хийсэн тэмдэглэл зэрэг бичгийн нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байна.</p>	<p>“...учруулсан хохирлыг төлсөн” гэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал, 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад заасан “энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн” гэх эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал” тус тус тогтоогдсон болно.</p>	<p>Шүүгдэгч Г.У-ын үйлдэл нь идэвхтэй, ухамсартай бөгөөд хууль бус болох нь илэрхий агал гэрээр шунахайн сэдгээр бусдын өмчлөх эрхэд халдсан байх тул түүнийг гэм буруугийн санаатай хэлбэрээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэнд тооцно.</p> <p>Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Г.У-ыг 270 /хоёр зуун дал/ цаг нийгэд тусгай ажил хийлгэх ял шийтгэсэн.</p>
<p>Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол 2022 оны 09 сарын 28 өдөр Дугаар 2022/ШЦТ/768</p>	<p>Г.У-ыг автобусанд зорчиж байсан иргэн А.Ш-ийн цүнхнээс Самсунг галакси А52 маркийн гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар хууль бусаар авч хулгайлан А.Ш-т 575,000 төгрөгийн хохирол, нийтийн тээврээр үйлчлүүлж явсан зорчигч Б.Л-гийн улаан хүрэн өнгийн түрүүвч, бэлэн 295,000 төгрөгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч хулгайлан Б.Л-д 313,000 төгрөгийн хохирол, автобусанд 7 буудлын орчимд С.П-гийн эзэмшлийн Samsung А52 загварын гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авч хулгайлан С.П-д 699,600 төгрөгийн хохирол тус тус учруулан бусдад нийт 1,587,600 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж, хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр шүүхэд ирүүлжээ.</p>	<p>Хохирогч нарт гар утас, бэлэн мөнгө зэргийг будаан өгснийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад заасан “учруулсан хохирлоо төлсөн” гэж үзэж хөнгөрүүлэх нөхцөлд тооцож, эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал тогтоогдсонгүй.</p>	<p>Шүүгдэгч Г.У-ын үйлдэл нь идэвхтэй, ухамсартай бөгөөд хууль бус болох нь илэрхий агал гэрээр шунахайн сэдгээр бусдын өмчлөх эрхэд халдсан байх тул түүнийг гэм буруугийн санаатай хэлбэрээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэнд тооцно.</p> <p>Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Г.У-ыг 270 /хоёр зуун дал/ цаг нийгэд тусгай ажил хийлгэх ял шийтгэсэн.</p>

ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТ ӨРТСӨН ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1. Хүн ам зүйн мэдээлэл

Тоон судалгаанд халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн 500 хүнийг хамруулж, хохирогчдын халаасны хулгайд эд зүйлсээ алдсан нөхцөл байдлыг тодорхойлох, Цагдаагийн байгууллагын халаасны хулгайтай тэмцэх үйл ажиллагаанд хандах сэтгэл ханамжийг тодорхойлох асуулга судалгаа авсан.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцаа

Хүйс	25 хүртэлх	26-35 нас	36-45 нас	46-55 нас	56-аас дээш	Нийт
Эрэгтэй	11.9%	10.7%	16.6%	5.2%	5.5%	49.9%
Эмэгтэй	10.7%	15.4%	13.6%	7.2%	3.2%	50.1%
Нийт	22.6%	26.1%	30.3%	12.4%	8.7%	100.0%

Судалгаанд оролцогчдын 49.9 хувийг эмэгтэйчүүд, 50.1 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн насны бүлэг болон хүйсийн харьцааг дээрх хүснэгтэд харууллаа.

График 1. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал




График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин



Судалгаанд хамрагдсан иргэдийг хөдөлмөр эрхлэлт болон боловсролын түвшнээр ангилан дээрх графикт харуулав. Нийт оролцсон иргэдийн 52.4 хувь нь буюу 2 хүн тутмын нэг нь хувийн хэвшлийн албан хаагчид бол 52.1 хувь нь бага, дунд, бүрэн дунд, тусгай дунд боловсролтой иргэд байна.

График 3. Судалгаанд оролцогчдын төрж, өссөн газар



Судалгаанд хамрагдсан иргэдийн төрж өссөн газраар нь харьцуулан харвал Улаанбаатар болон хөдөө орон нутагт төрж өссөн гэх хариултын хувь ойролцоо бөгөөд;

Улаанбаатар хотын уугуул болон суугуул иргэдийн хувьд халаасны хулгайд өртсөн тохиолдол нь 3.8 хувийн зөрүүтэй буюу олон нийтийн дунд тогтсон хөдөө орон

нутгийн хүмүүс халаасны хулгайд илүү өртдөг гэх ойлголт уг судалгаагаар тогтоогдоогүй.

2.2. Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн нөхцөл байдал

Халаасны хулгайн гэмт хэргийн нөхцөлд байдлыг тодорхойлохдоо судалгаанд оролцсон хүмүүсийн халаасны хулгайд өртсөн давтамж, халаасны хулгайд алдсан эд зүйлс, байршил, цаг хугацаа, хариу үйлдэл зэргийг тодрууллаа.

График 4. Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн давтамж




График 5. Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн давтамж, хүйсээр



Судалгаанд хамрагдсан иргэдийн талаас илүү буюу 57.3 хувь нь халаасны хулгайд 2 буюу түүнээс дээш удаа өртсөн байна. Тус үзүүлэлтийг хүйсээр харьцуулан харвал хоёр болон түүнээс олон удаа давтамжтайгаар эд зүйлээ халаасны халаасны хулгайд алдсан хүмүүсийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх жин эрэгтэйчүүдээс 10.1 хувиар илүү байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан иргэдийн дөрвөн хүн тутмын нэг нь (27.5 хувь) гурав болон түүнээс дээш удаа халаасны хулгайд өртсөн байна.


Шигтгээ

Цагдаагийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас:

Нөхцөл байдлаас харахад ихэвчлэн эмэгтэй, эсвэл насанд хүрээгүй, эсвэл ахимаг насны хүмүүс энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болдог. Яг гуч гаран насны эрэгтэй хүнээс авч чадахгүй. Тухайн хүний биеэ хамгаалах чадамжаас хамаардаг.


Халаасны хулгайн хулгайн гэмт хэрэг үйлдэж буй этгээд нь хохирогчоо сонгохдоо нас, хүйс, тухайн иргэний биеэ хамгаалах чадамжтай эсэх зэрэг хүчин зүйлээс харгалзан үзэж гэмт хэргээ үйлддэг.

График 6. Халаасны хулгайд алдсан эд зүйлсийн эзлэх хувиар



Халаасны хулгайнд өртсөн хүмүүсийн 86.1 хувь нь гар утсаа алдаж хохирчээ. Гар утсаа халаасны хулгайд алдсан иргэд гар утасны мөнгөн үнэлгээнээс гадна давхар хувийн мэдээллээ алдаж байна. Энэ нь бусдад хувийн мэдээллээ ашиглуулах, дансны мэдээллээ алдах, залилангийн гэмт хэргийн хохирогч болох зэрэг бусад эрсдэлийг дагуулдаг.

График 7. Халаасны хулгайд өртсөн байршил, хувиар



Халаасны хулгай ихэвчлэн гарч буй байршлын хувьд дөрвөн хүн тутмын нэг нь гудамж талбайд (26.1 хувь) мөн дөрвөн хүн тутмын нэг нь автобусанд (25.3 хувь) явж байх үедээ уг гэмт хэрэгт өртжээ.

Шигтгээ

Энэ оны наймдугаар сарын 07, 08-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд зохион байгуулагдсан 100 жилийн ойн баяр, наадмын үеэр 20 орчим гар утас, хөөрөг алдагдсан хэргийг цагдаагийн алба хаагчид илрүүлжээ.

Тодруулбал, 22-41 насны М, У, Э, М, А нарын бүлэг этгээдүүд тус аймгийн тэмдэглэлт ойн үеэр иргэдийн гар утас, хөөрөг зэргийг хулгайлсан байна.

Бүлэг этгээдүүдийг Улаанбаатар хот руу ирж байхад Налайх дүүргийн постод үүрэг гүйцэтгэж байсан алба хаагчид шалгаж, тээврийн хэрэгсэлд үзлэг хийж, 20 орчим гар утас, 1 ширхэг хөөргийг эд мөрийн баримтаар хураан авсан байна.

Эх сурвалж: gogo.mn¹⁸, 2024.08.12

Олон нийтийг хамарсан баяр ёслол нь тус гэмт хэргийн гаралтыг ихэсгэх, гэмт хэрэг үйлдэгч этгээдэд гэмт хэргээ үйлдэх таатай боломж байдаг. Гэсэн хэдий ч Улаанбаатар хотод гарсан гэмт хэргийн маш бага хувийг энэхүү үзүүлэлт бүрдүүлж байлаа. Энэ нь олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, шоу тоглолт нь цагдаагийн байгууллагын хараа хяналтад явагддагтай холбоотой байж болох юм. Харин хөдөө орон нутагт цагдаагийн албан хаагчийн тоо хангалттай бус, камерын хяналт хангалтгүй, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх туршлага сул зэрэг нь тус гэмт хэрэг гарах эрсдэлт орчин болж байна.

График 8. Халаасны хулгайд өртсөн нөхцөл байдал



¹⁸ https://gogo.mn/r/691xl?fbclid=IwY2xjawGDIC5leHRuA2FibQlxMQABHZE86sa3uNADcGgYnBxCtQt-6-Condpb98GMionPTA2ytSDQoBZcQsDcUg_aem_pnnDTo2103k9BTPmyEI32g

Судалгаанд хамрагдсан иргэдийн 86.4 хувь нь хулгайд эд зүйлээ алдсан эсхүл гээсэн эсэхээ тодорхой санаж байгаагаа илэрхийлжээ. Мөн өөрийн эд зүйлийг авсан хүний талаар ямар нэгэн таамаг байгаа гэж 42.2 хувь нь үзсэн байна.

График 9. Цагдаад хандахаас өөр бусад арга хэмжээ авсан эсэх, насны бүлгээр



Цагдаад хандахаас өөр бусад хэлбэрээр хайж үзсэн гэж хариулсан иргэд судалгаанд оролцогчдын 17.4 хувийг бүрдүүлж байна. Судалгаанд оролцогчдын нас залуужих тусам алдсан эд зүйлээ хайх эрмэлзэл тодорхой хэмжээнд нэмэгдэж байна. Тухайлбал судалгааны хамгийн залуу оролцогчдын буюу 25 хүртэлх насны хүмүүсийн 29.7 хувь нь өөр ямар нэг аргаар хайсан гэж хариулсан бол 56-аас дээш насны иргэдийн дунд тус үзүүлэлт 5.7 хувьтай байна.

График 10. Цагдаад хандахаас өөр бусад аргаар хайсан хэлбэр



Цагдаад хандахаас гадна өөрөө ямар нэг арга хэмжээ авсан гэж хариулсан иргэдээс ямар төрлийн арга хэмжээ авсныг тодруулан дээрх графикт харууллаа. Тэдгээр иргэдийн хамгийн өргөнөөр авдаг арга хэмжээ (камер шүүлгэх 57.1 хувь) нь тухайн байгаа газар, орчны камерыг шүүлгэдэг гэж хариулсан бол түүний дараагаар 17.1 хувь нь утасныхаа байршил тогтоогчоор хайж үзсэн гэж хариулсан. Бусад төрлөөр хайж үзсэн гэж хариулсан иргэдийн хувьд өөрөө байгаа орчиндоо хайсан, зарлуулсан, өөр эргэн тойронд байсан хүмүүсээс тусламж хүссэн зэргээр хариулт өгчээ. Үүнээс харахад иргэдийн багагүй хувь нь цагдаад мэдэгдэхээс гадна өөрөө арга хэмжээ авахыг хичээдэг болох нь харагдаж байна.

График 11. Халаасны хулгайд өртсөн цаг





График 12. Халаасны хулгайд өртсөн үеийн цаг агаарын төлөв байдал



График 13. Халаасны хулгайд өртөх үедээ өмсөж байсан хувцас



Халаасны хулгайд өртсөн хугацаа, цаг агаарын нөхцөл байдал, хэрхэн хувцасласан байсан зэрэг нөхцөл байдлыг дээрх графикт дүрслэн харууллаа. Энэ төрлийн гэмт хэргийн хамгийн идэвхтэй үе нь өдрийн цаг буюу 13:00 цагаас 17:00 цагийн хооронд байна. Тухайлбал энэ цагуудад эд зүйлээ алдсан гэж судалгаанд оролцогчдын 41.4 хувь нь хариулжээ. Мөн энэ хугацаа нь иргэдийн зорчих хөдөлгөөн, худалдаа үйлчилгээний байгууллагын хамгийн идэвхтэй цаг хугацаа байгаа нь уг үзүүлэлт өндөр байх шалтгаан болж байна.

График 14. Халаасны хулгайд эд зүйлээ алдсан байршил нь камерын хяналттай эсэх




Халаасны хулгайд өртсөн байршил нь камерын хяналттай байсан эсэх талаарх иргэдээс тодруулахад нийт судалгаанд оролцсон иргэдийн 54.3 хувь нь камерын хяналттай байсан гэж хариулсан бол 33.5 хувь нь камерын хяналтгүй байсан гэж хариулжээ. Тус үзүүлэлтийг эд зүйлээ алдсан байршлаар нь авч үзвэл дэлгүүр, үйлчилгээний байгууллагуудын 71.0 хувь нь камерын хяналттай байсан гэж хариулсан бол автобусанд эд зүйлээ алдсан иргэдийн 43.1 хувь нь камергүй байсан гэж хариулжээ. Үүнээс харахад

халаасны хулгайн гэмт хэрэг хамгийн их давтагдаж байгаа орчинд камерын хяналт харьцангуй сул, камер байгаа ч чанарын хувьд хэрэгтнийг таних, тодорхойлох шаардлагыг хангахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг гарах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна хэргийн илрүүлэлтийг удаашруулах, хэрэг илрэхгүй байх нөхцөл шалтгаан болж буй юм.

2.3. Хохирогчдын цагдаагийн байгууллагад хандсан туршлага, сэтгэл ханамж

Халаасны хулгайн гэмт хэрэгт эд зүйлээ алдсан иргэд цагдаагийн байгууллагад хэрхэн хандаж байгаа хийгээд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг судалгааны энэхүү хэсэг авч үзлээ.


График 15. Эд зүйлээ алдсаны дараагаар хаана, хэрхэн хандах талаар мэдэж байсан эсэх



Судалгаанд оролцсон иргэдийн хувьд халаасны хулгайд эд зүйлсээ алдсаны дараа хамгийн түрүүнд цагдаагийн байгууллагад түргэн шуурхай хандах нь гэмт хэргийн илрүүлэлтэд чухал ач холбогдолтой. Нийт судалгаанд

хамрагдсан иргэн эд зүйлээ алдсаныхаа дараа хаана хэрхэн хандах талаар мэдэж байсан гэж судалгаанд хамрагдсан иргэдийн 85.6 хувь нь хариулжээ. Энэхүү үзүүлэлт нь иргэд цагдаагийн байгууллагын шуурхай утас, хаяг байршлын талаарх мэдээлэл харьцангуй өндөр байгааг илтгэж байна.

График 16. Цагдаагийн байгууллагад өргөдөл гаргахад зарцуулсан хугацаа



Судалгаанд хамрагдсан халаасны хулгайд өртсөн иргэд цагдаагийн байгууллагад өргөдөл гаргахад нэг цаг хүртэлх хугацааг зарцуулсан гэж 42.2 хувь нь хариулжээ. Түүний дараагаар 33.5 хувь нь 1-5 цаг зарцуулсан бол 15.1 хувь нь нэг өдрөөс дээш хугацаа зарцуулсан гэж үзжээ.

График 17. Цагдаагийн байгууллага өргөдөл гомдолд эргэн хариу өгсөн хугацаа



Цагдаагийн байгууллагын түргэн шуурхай байдал, өргөдөл гомдол түргэн шуурхай хариу өгч буй байдал нь иргэдийн сэтгэл ханамжид чухал нөлөөтэй. Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд өөрийн гаргасан өргөдлийн хариуг хэр хугацаанд авсныг тодруулан дээрх графикт харууллаа.

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 25.3 хувь нь буюу дөрвөн хүн тутмын нэг нь өргөдлийн хариугаа авч чадаагүй гэж хариулжээ. Мөн бусад хариулагчид өөрийн гаргасан өргөдөл, гомдлын хариуг авсан ч хугацааны хувьд харилцан адилгүй байна.

График 18. Цагдаагийн байгууллага таны гаргасан гомдол, мэдээллийн дагуу хэрэг нээсэн эсэх





График 19. Гар утсаа хулгайд алдсан бол цагдаа танд хувийн мэдээллээ алдахаас сэргийлэх талаар зөвлөмж өгсөн



Судалгаанд оролцсон иргэдийн 82.9 хувь нь цагдаагийн байгууллага өргөдөл, гомдлын дагуу хэрэг нээсэн гэж үзэж байна. Үүнээс дүгнэхэд иргэд хэрэг бүртгэх болох мөрдөн шалгах ажиллагааны процессын ялгааг таньж мэдэхгүй байна. Мөн халаасны хулгайд гар утсаа алдсан иргэдэд цагдаагийн байгууллагын зүгээс хувийн мэдээллээ хамгаалах зөвлөмж өгсөн эсэхийг тодруулахад 69.2 хувь нь энэ талын мэдээлэл өгөөгүй гэж хариулжээ.

Үүнээс харахад цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа иргэдэд ил тод, ойлгомжтой байдлаар хүргэх, халаасны хулгайд өртсөн иргэдэд хувийн мэдээлэл хамгаалах зөвлөмж хүргүүлэх үйл ажиллагааг албажуулах, тогтворжуулахад илүү ач холбогдол өгч ажиллах шаардлагатай байна.

График 20. Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ (0-10 оноогоор)



Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн, халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчид цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг авбал зохих 10 онооноос 5.21 оноогоор үнэлсэн. Харин өөртэй нь харьцаж, үйлчилгээ үзүүлсэн цагдаагийн албан хаагчийн харилцаа хандлагыг 5.27 оноогоор, цагдаагийн албан хаагч хэргийг илрүүлэхийн тулд хичээл зүтгэл гаргасан байдлыг 3.53 оноогоор үнэллээ. Үүнээс үзэхэд иргэд цагдаагийн байгууллагын талаарх үнэлгээ харьцангуй сул байгаа бөгөөд хэрэг илрүүлэлтэд сэтгэл ханамж муутай байгаа нь илэрхий байна.

График 21. Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, хохирлоо нөхөн төлүүлсэн байдлаар (0-10 оноогоор)




Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн иргэд хохирлоо төлүүлж чадсан эсэхээсээ хамааран цагдаагийн байгууллагын талаарх сэтгэл ханамжийн түвшин харилцан ялгаатай байна. Тухайлбал өөрийн алдсан эд зүйлээ нөхөн төлүүлсэн иргэдийн үнэлгээ харьцангуй өндөр буюу 7.6-аас 8.5-ын хооронд хэлбэлзэж байгаа бол хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй иргэдийн үнэлгээ эрс бага буюу 2.4-өөс 4.8-ын хооронд байна. Цагдаагийн байгууллагын ерөнхий үнэлгээний түвшин тус хоёр бүлгийн хооронд хамгийн бага зөрүүтэй буюу 2.84 онооны зөрүүтэй байгаа бол хэрэг хариуцсан цагдаагийн албан хаагчийн үнэлгээний зөрүү хамгийн өндөр буюу 5.72 байлаа. Мөн энэхүү судалгаанд оролцогчдын ердөө 14.1 хувь нь хохирлоо нөхөн төлүүлж чадсан тул үнэлгээний түвшин ерөнхий сул байна.

График 22. Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, хувийн мэдээллээ хамгаалах зөвлөмж өгсөн эсэхээр




Халаасны хулгайн гэмт хэрэгт өртсөн иргэд цагдаагийн байгууллагад хандсаны дараа гар утсан дахь хувийн мэдээллээ хамгаалах зөвлөмж өгсөн байдал 26.2 хувьтай байсан. Цагдаагийн албан хаагчаас хувийн мэдээллээ хэрхэн хамгаалах талаар зөвлөмж авсан иргэдийн сэтгэл ханамж зөвлөмж өгөөгүй гэж үзэж байгаа иргэдийн сэтгэл ханамжаас харьцангуй өндөр байна. Үүнээс цагдаагийн албан хаагч өөрийн чиг үүргээ биелүүлэхдээ иргэдэд шаардлагатай зөвлөгөө мэдээллийг бүрэн дүүрэн өгөх нь иргэдийн сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлдэг болох нь нотлогдож байна.

График 23. Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, өргөдлийн хариу авсан хугацаагаар (0-10 оноогоор)



Цагдаагийн албан хаагчдын өргөдөл, гомдол түргэн шуухайн хариу өгдөг байдал нь судалгаанд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжид бодитой нөлөөлж байна. Хурдан хугацаанд өөрийн өргөдлийн хариу хүлээж авсан иргэдийн цагдаагийн байгууллага хийгээд, хэрэг илрүүлэх үйл ажиллагааны талаарх үнэлгээ өндөр байгаа бол хугацаа удаашрах тусам тус үзүүлэлт буурч байлаа.

График 24. Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн сэтгэл ханамжийн түвшин



Халаасны хулгайн гэмт хэрэгт өртөж, цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн 31.8 хувь нь буюу хамгийн жин дарах хэсэг нь нь сэтгэл ханамжийн түвшин маш муу гэж үнэлсэн байна. Нийт судалгаанд оролцогчдын 79.7 хувь нь сэтгэл ханамжийн түвшин дунд болон түүнээс доогуур байна.


Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн хувьд өргөдөл, гомдол гаргах, түүнээс хариу авах үе шат хүндрэлтэй хийгээд удаан бөгөөд, хэрэг илрүүлэх үйл явцад сэтгэл ханамж харьцангуй сул байлаа.

График 25. Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн сэтгэл ханамж, насны бүлгээр



Судалгаанд хамрагдсан халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчдын насны бүлэг ахих тусам сэтгэл ханамжийн түвшин буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал 25 хүртэлх насны залуучуудын 22.0 хувь нь маш муу сэтгэл ханамжтай гэж хариулсан бол, 56-аас дээш насны оролцогчдын 42.9 хувь нь маш муу үнэлгээ өгсөн.

График 26. Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн сэтгэл ханамж, өргөдлийн хариу авсан хугацаагаар



Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамж цагдаагийн байгууллагын өргөдлийн хариу өгсөн хугацаанаас хамаарч байна. Өргөдлийн хариуг 30 хоногийн дотор өгсөн тохиолдолд маш муу гэсэн үнэлгээ 40 хувиас бага байгаа бол 30-аас дээш хоногт хариу өгсөн бол уг үнэлгээ 40 хувь болон түүнээс өндөр байна.

2.4. Халаасны хулгайн гэмт хэргийн хохирогчдын хохирлыг барагдуулсан нөхцөл байдал

График 27. Хохирлоо төлүүлж чадсан байдал




График 28. Хохирлоо бүрэн төлүүлж чадсан бол хэрхэн төлүүлсэн хэлбэр



Судалгаанд хамрагдсан иргэдийн 85.9 хувь нь хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй гэж хариулжээ. Хохирлоо нөхөн төлүүлж чадсан гэж хариулсан иргэд 14.1 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тэдгээр иргэдийн 61.4 хувь нь эд зүйлээ эргүүлэн авсан, 29.8 хувь нь тохирох мөнгө авсан бол 5.3 хувь нь шинээр нөхөн төлүүлсэн байна.

График 29. Хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй шалтгаан



Хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй шалтгааныг тодруулахад судалгаанд оролцогчдын 42.9 хувь нь хэрэгтэн олдоогүй, 28.2 хувь нь цагдаагийн байгууллага, албан

хаагч хэргийг илрүүлэх ямар нэгэн үйлдэл хийгээгүй гэж үзэж байна. Иргэд хохирлоо нөхөн төлүүлж чадахгүй байгаа шалтгааны хувьд дээрх үндсэн хоёр хүчин зүйл хамгийн өндөр байна. Иргэдийн зүгээс хэрэг илрүүлэх байдлын талаарх мэдлэг, мэдээлэл хангалттай бус, хэргийн илрүүлэлтийн түвшин сул байгаа нь цагдаагийн байгууллагын талаарх сэтгэл ханамжийн төлөвийг бүрдүүлж байна.

ХАЛААСНЫ ХУЛГАЙН ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТЭД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

3.1 Халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлтэд тулгарч буй хүндрэлүүд

Халаасны хулгайн гэмт хэргийн нотлох баримтыг камерын бичлэггүйгээр бүрдүүлэхэд хүндрэлтэй байна. Тиймээс хотын камержуулалтыг нэмэх, ингэхдээ бичлэгийн чанар болон хадгалах хугацаа, ажиллагааг хангах нь чухал байна. Суурилуулсан камеруудад эвдрэл үүсэх, бичлэгийн чанар муу тул гэмт этгээдийг танихад хүндрэлтэй байна.

Хулгайн эд зүйлсийг худалдан борлуулах, гар дамжуулах, улмаар хил давуулах асуудалд хяналт тавих механизм бүрдүүлэх замаар хулгайн эд зүйлс худалдаалах зах зээлийг хумих талаар арга хэмжээ авах шаардлагатай байна. Судалгааны явцад гар утасны наймаа эрхлэгч хувь хүмүүс нь хулгайн эд зүйлс авч дамлан зарах бодит эрсдэл байгаа бөгөөд үүнд ямар нэгэн хяналт байхгүй байна. Хулгайн эд зүйлс дамлан борлуулах үйл ажиллагааг цаашид судалж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгосноор халаасны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, цаашлаад гэмт хэргийн гаралтыг зах зээлийг нь хянах замаар хязгаарлах боломжтой. Түүнчлэн барьцаалан зээлдүүлэх газруудтай хамтарч ажиллах хулгайн эд зүйлсийг авахгүй байх талаар зохицуулалтууд шаардлагатай байна.

Халаасны хулгайн эд зүйлсийг хил давуулахдаа гэмт этгээд өөрийн биеэр бус хөндлөнгийн хүнд дайвар байдлаар битүүмжилж явуулах, бусдад дамжуулах байдал нь гэмт хэргийн илрүүлэлтэд хүндрэл учруулж байна.

3.2 Албан хаагчид болон ажиллах орчин нөхцөл

Нийслэл хотын хэмжээнд халаасны хулгайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, дүүрэг орон нутаг дахь Цагдаагийн газар, хэлтсүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр нийт 26 албан хаагч ажилладаг.¹⁹ Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн албан хаагчид дараах үүргийг гүйцэтгэж байна.

1. Хэрэг материал бүрдүүлэх: Гэмт хэргийн талаарх бүх мэдээллийг цуглуулж, баримт бичиг боловсруулах.
2. Прокурорт шилжүүлэх: Хэргийн материал, баримтуудыг прокурорын хяналтад хүргэж, хэргийг үр дүнтэй шалгах.
3. Сэжигтнийг илрүүлэх: Гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийг олж тогтоох, тэдний талаар мэдээлэл цуглуулах.
4. Байцаалт авах: Хохирогч, сэжигтэн нарын мэдүүлэг авах, тухайн гэмт хэргийг тодруулан судлах болон бусад чиг үүргүүдийн дагуу ажиллаж байна.

¹⁹ Нийслэлийн цаг даагийн удирдах газрын халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн алба хаагчдын ажлын ачааллын тухай ярилцлагын тэмдэглэл, 2024 он

Улсын хэмжээнд гарч буй гэмт хэргийн нийт тоог үндэслэн Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд ажиллах үндсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

3.3 Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн албан хаагчдын ажлын орчин

Тусгай өрөөний дутагдал: Байцаалт, мэдүүлэг авах зориулалттай тусгай өрөө хангалтгүй учир, цагдаагийн албан хаагчид хохирогч, сэжигтэн болон хохирогчоос нэг дор нэг өрөөнд мэдүүлэг авах нөхцөл гардаг.

Ажлын орчин нөхцөл бүрэн хангагдаагүй үед ажилтан, албан хаагч ажилдаа төвлөрөх, бүтээмж өндөртэй ажиллахад хүндрэл учруулдаг. Түүнчлэн нэг өрөөнд олон албан хаагч ажиллаж байгаа нь орчны дуу чимээг нэмэгдүүлж, үнэн зөв мэдүүлэг авахад хүндрэл учруулдаг гадна мэдээллийн нууц алдагдах эрсдэлтэй нөхцөл үүсэж байна.

Техник хэрэгсэл. Халаасны хулгайтай тэмцэх хэлтэс нь албаны машин байгаа ч хүрэлцээ муу учир албан хаагчид ихэнхдээ хувийн машинаар ажил үүргээ гүйцэтгэдэг. Машины түлш болон шаардлагатай зардлыг хувиасаа гаргадаг. Машин, техникийн дутагдал нь гэмт хэргийн илрүүлэлтэд хугацаа алдах, ажил үүргээ хэвийн гүйцэтгэхэд саад болох эрсдэлтэй байна.

Албан хаагчид бие хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг хэрэглэх нөхцөлүүдийг тодорхойлсон дүрэм, журмыг боловсронгуй болгох шаардлагатай. Албан хаагч ажил үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын зүгээс халдлагад өртсөн тохиолдолд биеэ хамгаалах хэрэгсэл дутмаг, байгаа хэрэгслийг хэрэглэх эрх үүсээгүй зэрэг нь бэрхшээл болдог.

3.4 Халаасны хулгайн гэмт хэргийн хор хөнөөл

- **Халаасны хулгайн гэмт хэрэгтнүүд иргэдийн гар утсыг ихэвчлэн хулгайлж байна.**
 - Халаасны хулгайн гэмт хэрэгтнүүд иргэдээс хулгайлсан гар утсыг ашиглаж интернэт банк, зээлийн аппликейшнаас нь мөнгө зээлэх, хохирогчийн хувийн цахим хаягт нэвтэрч улмаар бусдаас мөнгө зээлэх байдлаар залилангийн гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй.
 - Хулгайн гар утсыг бусдад дамжуулах, зарж борлуулахдаа тухайн утсанд хадгалагдаж буй иргэний бичиг баримт, дурсамжит зураг, бичлэг, хадгалагдсан утасны дугаарууд, цахим шуудангийн мэдээлэл зэрэг үнэт мэдээллүүд дахин сэргээгдэх, нөхөн төлөгдөх боломжгүйгээр бүр мөсөн устаж байна.
- **Халаасны хулгай хийдэг хүмүүс нь цаашид өөр төрлийн гэмт хэрэгт үйлдэх өндөр эрсдэлтэй.**

Гэмт хэрэгтнүүд халаасны хулгайгаас гадна иргэдийн хувийн мэдээллийг ашиглан залилан хийх, бусдын биед халдах, сүрдүүлэх зэрэг гэм хохирол учруулж байна.

3.5 Халаасны хулгайн гэмт хэрэгт холбогдох эрх зүйн орчин

Халаасны хулгайн гэмт хэрэгтнүүд нь холбогдох эрх зүйн орчныг сайтар судалж, хуулийн зөвлөгөө авах замаар өөрсдийн эрх ашгаа хамгаалдаг. Халаасны хулгайн гэмт хэрэг нь эрүүгийн хуулийн 17.1 дэх заалтын дагуу “хөнгөн” гэмт хэрэгт тооцогддог тул сэжигтний гэм бурууг прокурор хялбаршуулсан горимоор шийдвэрлэх, гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэг үйлдэх явдал түгээмэл байна.

Хуулийн дагуу гэмт этгээдэд бусдад учруулсан хохирлын хэмжээнээс хамаарч зорчих эрх хязгаарлах, нийтэд тустай ажил хийх, 3-9 сарын баривчлах, хорих ял голлон хэрэглэж байна. Гэмт этгээдүүд эдгээрийг ялыг эдэлсэн ч дахин халаасны хулгайн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд дахин зорчих эрх хязгаарлах ял өгөх тохиолдол гарч байна.



Цагдаагийн албан хаагчид сэжигтэн этгээдийн ажлын орчин, орон гэрт прокурорын зөвшөөрөлгүйгээр нэгжлэг хийх боломжгүй. Судалгаанд оролцсон цагдаагийн албан хаагчдын үзэж буйгаар уг нөхцөл нь гэмт гэмт хэргийн үйлдлийг тогтоох, нотлох баримт цуглуулахад хүндрэл учруулж байна. Прокуророос нэгжлэг хийх зөвшөөрөл авах нь цаг хугацаа алдах, гэмт хэрэгтэнд хэргийн нотлох баримтыг нуун далдлах боломж олгох эрсдэлтэй байна. Тухайлбал халаасны хулгайд алдсан гар утасны байршил заагч сэжигтэн этгээдийн хувийн эзэмшил дотор зааж байсан ч цагдаагийн албан хаагч прокурорын зөвшөөрөлгүй бол тухайн айлд нэгжлэг хийх боломжгүй бөгөөд гэмт хэрэгтнүүд ч энэ талаар мэддэг тул утасны байршил заасан ч нэгжлэг хийлгэдэггүй байна.

Хуулийн дагуу прокурор болон шүүгчийн албадан ирүүлэх зөвшөөрөл шаардагддаг бөгөөд зөвшөөрөлгүй нөхцөлд сэжигтэн этгээдийг дуудан ирүүлэх, байцаалт авах боломжгүйгээс шалтгаалж гэмт хэрэг илрүүлэлт удаашрах нөхцөл үүсэж байна. Тиймээс шүүх болон прокурорын зөвшөөрлийг цаг алдалгүй авах боломжийг судлах, цагдаагийн албан хаагчийн эрх зүйн нөхцөл байдлыг дээшлүүлэх, хамгаалах механизмыг сайжруулах шаардлагатай байна.

ДУГНЭЛТ

Цагдаагийн байгууллагын ерөнхий үйл ажиллагааны талаарх халаасны хулгайн гэмт хэргийн хохирогч иргэдийн үнэлгээ нь авбал зохих 10 онооноос 5.21 оноо байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 79.7 хувь нь сэтгэл ханамжийн түвшин дунд болон түүнээс доогуур, тал хувь нь муу (маш муу-31.8%, бага зэрэг муу-17.9%) гэж үнэлжээ.

Иргэдийн сэтгэл ханамжид нэгдүгээрт хэрэг илрүүлэлтийн түвшин, хоёрдугаар иргэдийн хохирлын нөхөн төлүүлж хохиролгүй болгож буй байдал, гуравдугаарт цагдаагийн байгууллагын албан хаагчийн харилцаа хандлага нөлөөлж байна.

Цагдаагийн байгууллагад өргөдөл гаргаж үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийн түвшин нь түргэн шуурхай, тодорхой үйлчилгээ авсан байдал, албан хаагчид зохих зөвлөгөө мэдээллээр хангасан байдал зэргээс шалтгаалан өөрчлөгдөж байна. Тухайлбал цагдаагийн албан хаагч хохирогч иргэдэд зөвлөмж мэдээлэл өгөх нь байгууллагын үйл ажиллагааны үнэлгээг 20.3 хувиар, албан хаагчийн харилцаа хандлагын үнэлгээг 20.6 хувиар тус бүр өсгөж байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан дөрвөн хүн тутмын нэг нь цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл гомдолд хариу өгөөгүй гэж хариулжээ. Хохирлоо нөхөн төлүүлсэн иргэд цагдаагийн байгууллага болон албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ 7.6-8.4 оноогоор буюу харьцангуй өндрөөр үнэлсэн бол хохирлоо нөхөн төлүүлээгүй хэрэг хаалгасан иргэд 2.4-4.8 онооны хооронд үнэлсэн байна.

Цагдаагийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд гэмт хэргийг илрүүлэх нь чухал бол иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд тэдний хохирлыг бүрэн барагдуулах нь чухал байна. Иймд зөвхөн илрүүлэлтэд анхаарах бус хохирол барагдуулахыг чухалчлах нь зүйтэй.

Иргэдийн сэтгэл ханамжид нөлөөлөгч бусад хүчин зүйлсийг тогтоож, хэрэгжүүлэхгүй байгаа нь үнэлгээ муу байхад нөлөөлж байна. Тухайлбал цагдаагийн байгууллагын албан хаагч иргэдийг мэдээллээр хангах, хэрэг шийдвэрлэх үе шатын талаарх ойлголтыг өгч, хэрэг илрүүлэх үйл явцыг тогтмол мэдээлж иргэдэд тодорхой ойлгомжтой ажиллах нь иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Хариу үйлдэл, ил тод байдал, технологийн дэвшил, иргэдийн оролцоо зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр арга хэмжээ нь цагдаагийн байгууллага ба иргэдийн харилцан итгэлцлийг бэхжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой.

Халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд дараах асуудал тулгамдаж байна. Үүнд:

Камержуулалт: Халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлтийн дийлэнх нь камерын бичлэгийн тусламжтай шийдвэрлэгдэж байна. Камергүй болон камертай ч чанарын шаардлага хангахгүй байгаа бүсүүдэд энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт удаашрах болон шийдвэрлэгдэхгүй байх үндсэн нөхцөл шалтгаан болж байна. Тиймээс камержуулалт, технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх нь дан ганц халаасны хулгай бус бусад төрлийн гэмт хэргийн ч мөн адил гаралтыг бууруулах болон үйлдэгдсэн аливаа гэмт хэргийн нотлох баримтыг бүрдүүлж шийдвэрлэхэд чухал нөлөөтэй.

Эрх зүйн орчин: Монгол улсад мөрдөгдөж буй хууль, дүрэмд халаасны хулгайн гэмт хэргийг тодорхойлсон тодорхойлолт байхгүй бөгөөд Эрүүгийн хуулийн 17.1 дэх заалтыг үндэслэн ял, шийтгэл оногдуулж байна. Шүүхийн практикт халаасны хулгайн гэмт хэрэгтнүүдэд хөнгөрүүлсэн хэлбэрээр шийтгэл оногдуулж буй нь гэмт хэргийн гаралтыг

бууруулах чиглэлд үр нөлөө сул, гэмт хэрэгтнүүд давтан гэмт хэрэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Эдийн засгийн хязгаарлалт:

Халаасны хулгайн гэмт хэргийн дийлэнх хувийг гар утасны хулгайн гэмт хэрэг эзэлж байна. Энэхүү судалгаанд хамрагдсан иргэдийн 86.1 хувь нь гар утсаа хулгайд алдсаны улмаас цагдаагийн байгууллагад ханджээ. Хулгайн гар утас, эд зүйлсийг зарж борлуулах, дамжуулах, хилээр гаргах, оруулах зэрэгт хяналт тавих механизм сул байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлж байна. Тиймээс гар утас худалдан борлуулж байгаа дэлгүүр, засварын газар, хувь хүмүүс хулгайн гар утас худалдаж авах, борлуулахаас урьдчилан сэргийлэх нь энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулахад чухал үр нөлөөтэй. Халаасны хулгайн гар утасны зах зээлийг хумих, худалдан борлуулах үйл ажиллагааг хянах үүднээс хулгайд алдагдсан гар утасны нэгдсэн сан бий болгож иргэд болон гар утас худалдаа эрхлэгчид хуучин гар утас худалдан авахдаа тус сангаар утасны сериал дугаараар шалгасны дараагаар худалдаж авах зэргээр иргэдийн үйл ажиллагаанд хэвшүүлэх шаардлагатай.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны хүрээнд иргэдийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгч буй сэтгэл ханамжийг сайжруулах дараах үндсэн саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. **Шуурхай хариу үйлдэл ба эргүүл.** Халаасны хулгайн гэмт хэрэг гарсан даруйд шуурхай арга хэмжээ авах. Үүний тулд Цагдаагийн газар иргэдийн дуудлагад хурдан хариу өгөх, хэргийн явцыг шуурхай шалгах албан хаагчдыг нэмэгдүүлэх нь зүйтэй. Түүнчлэн гудамж, зах зэрэг олон хүн цуглардаг газарт олон нийтэд ил тод харагдахуйцаар байнгын эргүүл ажиллуулах. Уг ажлын үр дүнд иргэд цагдаагийн байгууллагаас шуурхай хариу авснаар аюулгүй байдлын мэдрэмж нэмэгдэж, сэтгэл ханамж дээшлэх боломжтой.
2. **Хохирогчийн сэтгэл зүйг анхаарах.** Хохирогчдод зөвлөгөө өгч, хэргийн явцын талаар байнга мэдээлэх. Үүний үр дүнд хохирсон иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ. Мөн мэдээлэгчийг хамгаалах, урамшуулах нь чухал.
3. **Гэмт хэрэг илрүүлэх технологийг сайжруулах.** Халаасны хулгайн гэмт хэргийн илрүүлэлтэд технологийн боломжийг ашиглаж, хяналтын системийг боловсронгуй болгох: Камерын хяналттай ногоон бүсүүдийг нэмэгдүүлэх, камерын хэвийн ажиллагааг хангах мөн хиймэл оюун ашиглан гэмт хэргийг илрүүлэх ажлыг сайжруулах. Түүнчлэн иргэдээс ирсэн мэдээллийг боловсруулах, хариу өгөх хурдыг нэмэгдүүлэх: Ингэхдээ мэдээллийг цахим платформоор хурдан хүлээн авч шалгах боломжийг бүрдүүлэх. Уг ажлын үр дүнд халаасны хулгай гэмт хэрэг илрүүлэлт сайжирснаар иргэдийн итгэл нэмэгдэж, цагдаагийн албаны үйл ажиллагаанд өгөх үнэлгээ өснө.
4. **Ил тод байдлыг нэмэгдүүлэх.** Халаасны хулгайн гэмт хэргийн шалгалтын ажлын талаар хохирогчдод цахим хэлбэрээр эсвэл, утсаар мэдээлэл өгч, иргэдэд итгэл төрүүлэх, халаасны хулгайн хэргийн шийдвэрлэлийн талаар олон нийтэд нээлттэй мэдээлэх байдлаар цагдаагийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх. Хэргийг шалгах явц болон шийдвэрлэлт нь иргэд цагдаагийн байгууллагын ойлголцлыг сайжруулж, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.
5. **Иргэдтэй хамтран ажиллах.** Гэмт хэргээс сэргийлэх сайн дурын эргүүл ажиллуулах зэргээр гэмт хэрэгтэй тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг оролцуулах, гэмт хэргийн талаар үнэн зөв мэдээлэл өгсөн мэдээлэгчийг урамшуулах тогтолцоог цагдаагийн үйл ажиллагаанд нэвтрүүлснээр халаасны хулгайн гэмт хэргээс сэргийлэх боломжтой. Уг ажлын үр дүнд иргэдийн сэтгэл ханамжийг цагдаагийн байгууллага иргэдийн хамтын ажиллагаагаар нэмэгдүүлэх боломжтой.
6. **Үйлчилгээний соёлыг дэмжих.** Цагдаагийн албан хаагчид иргэдтэй харьцахдаа хүндэтгэлтэй, ойлголцолтой хандах зэрэг харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх, цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээс цаг тухай бүрд нь сэтгэл ханамжийн судалгаа авч үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах боломжтой. Харилцаа, үйлчилгээний чанар дээшилснээр иргэдийн итгэл нэмэгдэж, цагдаагийн байгууллагад өгөх үнэлгээ өснө.

Судалгааны бусад саналууд

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цагдаагийн байгууллага бусад байгууллагуудтай хамтарч ажиллах. Ингэхдээ иргэдийг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалахаас гадна, гэмт хэрэг үйлдэж болзошгүй бүлэгт хандсан сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах.
2. Цагдаагийн үйл ажиллагааг үнэлэхдээ хэрэг илрүүлэлтээс гадна хохирогчид шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлсэн эсэх цагдаагийн байгууллагын үйл

ажиллагааны талаар хохирогчид цаг тухайд нь мэдээлэл өгч ажилласан байдал зэргээр үнэлэх үнэлгээний системийг боловсруулж, бүртгэлийг төгөлдөржүүлэн мөрдүүлэх шаардлагатай.

3. Халаасны хулгайн гэмт хэрэгт оногдуулж буй ялын бодлогыг сайжруулах, боловсронгуй болгоход чиглэсэн ажлуудыг зохион байгуулах.
4. Хулгайн бараа бүтээгдэхүүн зарж, борлуулах, худалдан авах байдалд хяналт тавих замаар зах зээлийг хумих арга хэмжээ авах.
5. Халаасны хулгайн гэмт бүлэглэл, сүлжээг илрүүлэх, таслан зогсоох чиглэлд гүйцэтгэх ажиллагаа явуулах.
6. Албан хаагчдын эрх зүйн байдлыг дээшлүүлэх, ажлын байр, тоног төхөөрөмжийг сайжруулах.